



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/331

Хэрлэн сум

Г.Батсайханд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Хэрлэн сумын иргэн Г.Батсайханаас ирсэн хүсэлтийн дагуу улсын аварга шалгаруулах Мөрөөдлийн гоол хөл бөмбөгийн тэмцээнд оролцоход нь 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулгад)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ